



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, Соёлын өвийн үндэсний төвийн дүрмийн 3.3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын дотоод журамд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тусган боловсруулсны дагуу “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Хөдөлмөрийн дотоод журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

3. Дотоод журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (А.Ганбат)-т, журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусган батлуулахыг Санхүү, аж ахуйн алба (Ч.Өнөртогтох)-нд даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Үндэсний төвийн захирлын 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн “Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлах тухай” А/13 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Г.ЭНХБАТ

1725010054



مصدق من مصدق من مصدق و
مصدق من مصدق من مصدق

مستند شماره ۱۳۴

فمنس 22/4/22

نور و نور (نور) نور

وہمضیٰ منہ لہم وہمضیٰ منہ لہم وہمضیٰ منہ لہم
وہمضیٰ منہ لہم وہمضیٰ منہ لہم وہمضیٰ منہ لہم

[illegible]

6. «وختنیمیز» لدر مهمتوقو للاحم فو، یصیغسوقو نیسچر، یلدرتسچسچر لدر صمرسچر قیورمختسچسچر و جنتوقو
 رلچسچر لدر مهمتوقو للاحم» - ن سورمخچر کمرمتس یلدرتسچر و یصیغسچر

[illegible][illegible][illegible]

مكتب التسجيل
الهيئة العامة للغذاء والدواء
YMAH6A.TAP.XOT
9104208 KH17839
1118255933

1725010054

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2025 оны 43 дугаар сарын 21 -ны өдрийн
A/11 дугаар тушаалын хавсралт



ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Соёлын өвийн үндэсний төв (цаашид “Үндэсний төв” гэх)-ийн Хөдөлмөрийн дотоод журам (цаашид “Дотоод журам” гэх)-ын зорилго нь Үндэсний төвийн дотоод үйл ажиллагааг зохион байгуулах, төлөвлөх, тайлагнах, захиргаа болон ажилтны хооронд үүсэх хөдөлмөрийн харилцааг зохицуулах, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах, ёс зүй, шагнаж урамшуулах, тусламж, тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Үндэсний төв нь үйл ажиллагаандаа Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон энэхүү дотоод журмыг дагаж мөрдөнө.

1.3.Хөдөлмөрийн дотоод журмыг шинээр баталсан, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд нийт ажилтанд танилцуулж, мэдээллийн самбарт байршуулна.

Хоёр. Үндэсний төвийн удирдлага, зохион байгуулалт

2.1.Үндэсний төв нь Соёлын сайдын 2022 оны A/116 дугаар тушаалаар баталсан дүрэм, бүтэц, зохион байгуулалтаар ажиллана.

2.2.Үндэсний төвийн захирал байгууллагын үйл ажиллагааг нэгдмэл удирдлагаар хангах бөгөөд захирлын дэргэд дотоод үйл ажиллагаатай холбогдсон асуудлыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, зөвлөх эрхтэй Захиргааны зөвлөл ажиллана. Захиргааны зөвлөл нь газар, албаны дарга нар, хамт олныг төлөөлж Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

2.3.Үндэсний төвийн дэргэд орон тооны бус Соёлын биет өвийг таньж тогтоох шинжээчийн зөвлөл, Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийг таньж тогтоох шинжээчийн зөвлөл, Эрдмийн зөвлөл байна.

2.4.Дотоод журмын 2.2, 2.3-т заасан Зөвлөлүүдийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Үндэсний төвийн захирлын тушаалаар батална.

2.5.Үндэсний төв нь үйл ажиллагааны чиглэл, бүтцийн дагуу Захиргаа, удирдлагын газар, Бүртгэл, мэдээллийн газар, Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газар, Сэргээн засварлах газар, Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг хамгаалах газар, Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газар, Мэдээллийн технологийн газар гэсэн үндсэн 7 нэгжтэй байна.

2.6.Үндсэн нэгж (цаашид “зохион байгуулалтын газар, нэгж” гэх) нь хариуцсан тодорхой үүрэг, чиглэл, ажлын гүйцэтгэл, үр дүнг захирлын өмнө бүрэн хариуцаж ажиллах ба захиран зарцуулах эрх нь Үндэсний төвийн захиралд хадгалагдана.

2.7.Үндэсний төвийн захирлыг 1-90 хүртэл хоног эзгүй тохиолдолд түүнийг Захиргаа, удирдлагын газрын дарга орлож, мэргэжлийн удирдлагаар хангах бөгөөд гүйцэтгэсэн ажлаа захиралд тайлагнаж, гаргасан шийдвэрээ хариуцна.

2.8.Газар, нэгжийн даргыг түр эзгүй тохиолдолд (ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй, томилолттой) Үндэсний төвийн захирал Захиргаа, удирдлагын газрын даргыг, Бүртгэл, мэдээллийн газрын даргыг Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч, Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газрын даргыг Ерөнхий технологич, Сэргээн засварлах газрын даргыг Ерөнхий сэргээн засварлагч, Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг хамгаалах газрын даргыг Авран хамгаалах эрсдэлийн судалгааны газрын дарга, Авран хамгаалах эрсдэлийн судалгааны газрын даргыг Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газрын дарга, Мэдээллийн технологийн газрын даргыг Бүртгэл, мэдээллийн газрын дарга орон ажиллана.

2.9.Газар нэгжийн дарга өөрийн харьяалан удирдах ажилтны өдөр тутмын үйл ажиллагааг чиг үүргийн хүрээнд удирдлага, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана.

2.10.Ажилтан албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүрэг, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын гүйцэтгэлийг газар, нэгжийн даргын өмнө хариуцаж тайлагнана.

2.11.Газар, нэгжийн дарга бусад газрын ажилтанд үүрэг даалгавар өгөх тохиолдолд харьяалах газрын даргаар дамжуулна. Шуурхай шийдвэрлэх албан ажлын шаардлагаар холбогдох ажилтантай шууд харилцах бөгөөд энэ тухай ажилтан харьяалах газрын даргадаа мэдэгдэнэ.

2.12.Захирлаас ажилтанд үүрэг даалгавар өгсөн тохиолдолд өөрийн харьяалах газрын даргадаа танилцуулж, заасан хугацаанд гүйцэтгэлийг тайлагнана.

2.13.Үндэсний төвийн албан ёсны мэдээ, мэдээллийг Захиргаа, удирдлагын газрын даргаар хянуулж, захирлын зөвшөөрснөөр олон нийтэд мэдээлнэ.

Гурав. Үндэсний төвийн дотоод үйл ажиллагаа

3.1.Захирал нь байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар холбогдох хууль, журам, дээд газрын тогтоол шийдвэрт нийцүүлэн тушаал гаргана (цаашид “тушаал” гэх). Тушаалын хэрэгжилтийн явцад холбогдох газрын дарга хяналт тавьж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.2.Газар, нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг газрын дотоод журмаар зохицуулах бөгөөд захирлын тушаалаар батална.

3.3.Ажилтан гадаад, дотоодод томилолтоор ажиллахад, сургалтад хамрагдах, хурал бусад арга хэмжээнд оролцоход захирлын тушаал гаргана. Томилолтын үр дүнг захиралд илтгэх хуудсаар танилцуулна. Сургалт, томилолтын тухай илтгэх хуудсыг Санхүү, аж ахуйн албанд, томилолтоор ажилласан тухай тайланг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд өгнө.

Дөрөв. Төлөвлөгөө, тайлан, хэрэгжилтэд тавих хяналт

4.1.Үндэсний төвийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, хэрэгжилт хяналт:

4.1.1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах саналаа газар, нэгжүүд дараа оны 01 дүгээр сард багтаан боловсруулах бөгөөд төлөвлөгөөний төслийг Захиргаа, удирдлагын газар нэгтгэж, Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж, захиралд танилцуулна.

4.1.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг улирлаар дүгнэж цаашид авах арга хэмжээний талаар Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэнэ.

4.1.3.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас, бүтэн жилийн тайланг 06 дугаар сарын 01, 12 дугаар сарын 01-ний дотор хамт олны хурлаар тайлагнах бөгөөд Захиргаа, удирдлагын газар зохион байгуулна.

4.2.Газар, нэгжийн төлөвлөгөө, тайлан, хэрэгжилт хяналт:

4.2.1.Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг газар, нэгжийн дарга нар Үндэсний төвийн захиралтай байгуулна.

4.2.2.Газар, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирлаар дүгнэж, биелэлтийг хангаж ажиллана.

4.3.Ажилтны төлөвлөгөө, тайлан, хэрэгжилт хяналт:

4.3.1.Ажилтан нь газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу ажлаа төлөвлөж, гүйцэтгэлийг хангаж, ажлын үр дүн явцыг газрын даргад танилцуулж ажиллана.

4.3.2.Ажилтны гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл, үр дүнг газрын дарга дүгнэж, биелэлтийг хангуулж хяналт тавьж ажиллана.

Тав. Дотоод ажлын зохион байгуулалт

5.1.Үндэсний төв нь долоо хоног бүрийн Даваа гарагт газрын дарга нарын хурлыг хийнэ. Хурлаар өнгөрсөн долоо хоногт гүйцэтгэсэн ажил, удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт, явцын талаар газар, нэгжийн даргын мэдээллийг сонсож тухайн долоо хоногт гүйцэтгэх ажлын талаарх холбогдох үйл явц, арга хэмжээг төлөвлөнө.

5.2.Архив, бичиг хэргийн ажилтан хурлын тэмдэглэл хөтөлж баталгаажуулан, хурлаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийн биелэлтэд Захиргаа, удирдлагын газрын дарга хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авна.

5.3.Газар, нэгжүүд сард 1 удаа, байгууллагын нэгдсэн хурал жилд 2-оос доошгүй удаа хуралдаж ажлын тайлан, цаг ашиглалт, сахилга хариуцлага, онцгой амжилт гаргасан ажилтан, газар нэгжийн ажлын туршлага, алдаа дутагдал болон цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэнэ.

Зургаа. Үндэсний төвийн тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх, хадгалах

6.1.Үндэсний төвийн “Албан хэрэг хөтлөлтийн журам”-ыг батлуулан мөрдөж ажиллана.

6.2.Үндэсний төвийн тэмдэг түших, баталгааны тэмдэг хийлгэх, хэрэглэх, хэвлэмэл хуудас хэрэглэх, хадгалах зэрэг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг “Албан хэрэг хөтлөлтийн журам”-аар зохицуулна.

Долоо. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

7.1.Үндэсний төв нь хууль тогтоомжид заасны дагуу гадаад, дотоодын ижил төрлийн байгууллага, иргэнтэй харилцан тэгш эрхийн үндсэн дээр хамтын үйл ажиллагаагаа хөгжүүлнэ.

7.2.Бусад байгууллагын баримт бичиг, тусгайлан заагаагүй бол гадаад, дотоодын гэрээ, албан бичигт захирлын зөвшөөрөлгүйгээр байгууллагын хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэхийг хориглоно.

7.3.Гадаад хамтын ажиллагаатай холбоотой санамж бичиг, гэрээ байгуулахдаа Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”-ыг баримтална.

Найм. Хамтын гэрээ байгуулах

8.1.Үндэсний төвийн захиргаа нь ажилтны сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн Үйлдвэрчний эвлэлийн салбар хороотой хамтын гэрээ байгуулж, дүүргийн Засаг даргын Тамгын газарт бүртгүүлнэ.

8.2.Хамтын гэрээг байгуулахдаа харилцан эрх тэгш, ил тод, хууль тогтоомжид нийцсэн, гэрээнд тусгах асуудлаа чөлөөтэй сонгон хэлэлцэж, сайн дураараа хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой тусгасан байна.

8.3.Хамтын гэрээнд Хөдөлмөрийн тухай хуулийн 18, 19, 20, 21, 22, 23, 24 дүгээр зүйлд заасан нөхцөлүүдийг тусгана.

8.4.Хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг аль ч тал санаачилж болно.

8.5.Талууд хамтын гэрээнд хүлээсэн үүргээ биелүүлэх, гэрээний биелэлтэд хяналт тавих, түүний явцыг гэрээнд заасан хугацаанд нийт ажилтанд мэдээлнэ.

Ес.Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүсгэх,
хөдөлмөрийн гэрээ байгуулах,
хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгох

9.1.Ажлын байрны сул орон тоонд байгууллагын ажилтнуудаас мэргэжил, ажлын туршлага, гүйцэтгэх ур чадварыг нь харгалзан харьяалах газрын даргын саналыг үндэслэн дэвшүүлэн томилж болно.

9.2.Хүний нөөцийн ажилтан ажлын сул орон тоог олон нийтийн цахим сүлжээ, байгууллагын цахим хуудсаар мэдээлж, ажилд орохыг хүссэн иргэний материалыг хүлээн авч судалсны үндсэн дээр зохих баримт бичгийг бүрдүүлэн захирал, холбогдох газар, нэгжийн даргад танилцуулна.

9.3.Эзэмшсэн мэргэжил, мэргэшлийн зэрэг, ур чадварыг харгалзан иргэнийг сонгон шалгаруулах журмаар ажилд авна.

9.4.Ажилд шинээр орж буй иргэнийг тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангах эсэхийг нь шалгах зорилгоор туршилтын 3 сарын хугацаагаар ажиллуулна. Ажилтантай харилцан тохиролцсоноор нэг удаа 3 сараас илүүгүй хугацаагаар туршилтын хугацааг сунгаж болно.

9.5.Ажилд орох иргэн дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

- а) Ажилд орохыг хүссэн өргөдөл (гараар бичсэн),
- б) Төрийн албан хаагчийн анкет,
- в) 4*6 хэмжээний цээж зураг,
- г) Иргэний үнэмлэхийн хуулбар (эх хувьтай тулган үзэх ба E-Mongolia цахим сайтаас авсан хуулбар),
- д) Боловсролын үнэмлэх, дипломын хуулбар (эхтэй нь тулган үзэх ба E-Mongolia цахим сайтаас авсан хуулбар),
- е) Нийгмийн даатгалын тодорхойлолт, лавлагаа,
- ё) Хувь хүний намтар,
- ж) Цэргийн алба хаасан тухай баримт,

9.6.Туршилтын хугацаагаар хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүсгэсэн ажилтныг албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг гүйцэтгүүлж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах ба мэргэшил, ур чадвар нь ажил үүргээ гүйцэтгэхэд хангалттай гэж үзвэл туршилтын хугацаа дуусмагц газар, нэгжийн дарга үндсэн ажилтнаар томилуулах саналаа захиралд танилцуулах бөгөөд захирал шийдвэрлэнэ.

9.7.Захирал шинээр ажилд орж буй иргэнтэй хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг тохиролцож 2 тал харилцан зөвшөөрсөн тохиолдолд хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулна. Хөдөлмөрийн гэрээний нөхцөл өөрчлөгдөх тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт өөрчлөлт оруулж болно.

9.8.Ажилтантай хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүсгэсэн тухай шийдвэр гарсны дараа байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, дотоод журам, бусад журам, ёс зүйн дүрмийг Хүний нөөц хариуцсан ажилтан “Танилцуулах хуудас” (журмын 1 дүгээр хавсралт)-аар танилцуулж, гарын үсгээр баталгаажуулсан байна.

9.9.Туршилтын хугацаанд албан үүргээ хангалттай биелүүлээгүй ажилтныг мэргэшил, ур чадварын хувьд тухайн албан тушаалд тэнцэхгүй гэж үзвэл газар, нэгжийн дарга ажлаас чөлөөлөх саналаа захиралд танилцуулж, захирал шийдвэрлэнэ.

9.10.Ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тодорхой ажлын байранд ажиллуулахаар бэлтгэх, мэргэшүүлэх зорилгоор ажилтантай харилцан тохиролцсоны үндсэн дээр газар, нэгж дотор болон бусад газар, нэгжид 3 жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно.

9.11.Ажилтны хөдөлмөрийн гэрээг Хөдөлмөрийн тухай хуулийн 78, 79 дүгээр зүйлд заасан үндэслэлээр дуусгавар болно.

9.12.Хүндэтгэн үзэх шалтгаантай, эсхүл ажлаас чөлөөлөх хугацааг тохиролцсон бол хөдөлмөрийн гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

9.13.Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.1, 80.1.2, 80.1.3, 80.1.4, 80.1.5, 80.1.6 дахь заалт, хөдөлмөрийн гэрээ, энэхүү дотоод журам зөрчсөн нь нотлогдсон бол ажилтны хөдөлмөрийн гэрээг захиргааны санаачилгаар цуцлах үндэслэл болно.

9.14.Захиргааны санаачилгаар хөдөлмөрийн харилцааг цуцлах тухай ажилтанд 30-аас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэх бөгөөд хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэлийг танилцуулж, танилцуулсан тухай тэмдэглэл үйлдэнэ.

9.15.Захирлын тушаалаар хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүсгэсэн, дуусгавар болгосон бол Төрийн албаны ХНУМТ цахим систем (Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо), ТБДҮАУНС (Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем) ERP E-Mongolia систем, байгууллагын ирц бүртгэлийн программ, албаны цахим шууданд нэвтрэх эрх олгох, нэмэх, хасах асуудлыг Мэдээллийн технологийн газар, Хүний нөөцийн ажилтан хариуцан гүйцэтгэнэ.

9.16.Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болж буй ажилтан тушаалд заасан хугацаанд ажлаа цахим болон цаасан хэлбэрээр, хариуцсан эд хөрөнгөө бүртгэлийн дагуу хүлээлгэн өгч, "Тойрох хуудас" (журмын 2 дугаар хавсралт)-ыг зуруулж, холбогдох тооцоог хийнэ.

9.17.Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон болон жирэмсний, хүүхэд асрах чөлөө авч буй ажилтны ажил хүлээлцэх ажлыг харьяалах газар, нэгж зохион байгуулж, ажил хүлээлцсэн актыг үйлдэж Хүний нөөцийн ажилтанд өгнө.

9.18.Хүний нөөцийн ажилтан албан хаагчийн хувийн хэргийн нууцлал, хадгалалт, хамгаалалтад холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллана.

Арав. Цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нөхөх төлбөр

10.1.Ажилтанд олгох үндсэн цалин хөлсний хэмжээг Засгийн газрын тогтоол шийдвэрийн дагуу тухайн ажилтны албан тушаалын ангилал, зэрэглэлийг үндэслэн захирлын тушаалаар тогтооно. Ажилтанд албан тушаалын цалин хөлс, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, докторын зэрэг, профессор цолны, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг холбогдох хууль, журмын дагуу олгоно.

10.2.Ажилтны хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлсийг тооцож сар бүрийн 10, 25-ны өдөр олгоно. Цалин олгох өдөр нь долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарвал өмнөх ажлын өдөрт шилжүүлэн олгоно.

10.3.Ажлын гүйцэтгэл нь ажилтны буруугаас шалтгаалаагүй бол түүнд ажилласан хугацааны цалин хөлсийг олгоно.

10.4.Ажилтан өөрийн буруугаас хариуцсан ажил үүргээ гүйцэтгээгүй бол гүйцэтгэсэн ажилд нь тохирсон цалин хөлсийг олгоно.

10.5.Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг хавсран гүйцэтгэх албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар тооцно.

10.6.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны, эрх бүхий албан тушаалтны, нууцын ажилтны, ёс зүйн дэд хорооны гишүүний, өмч хамгаалах байнгын зөвлөлийн гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс шалтгаалж нэмэгдэл, урамшууллын хэмжээг холбогдох, хууль журамд нийцүүлэн захирлын тушаалаар тогтоож олгоно.

10.7.Ажилтанд өдрийн унаа, хоолны нэмэгдлийг тухайн оны нэгдүгээр сарын 02-ны өдрийн цалин хөлс, нэмэгдлийг тогтоосон захирлын тушаалын дагуу олгоно.

10.8.Ур чадварын нэмэгдлийг захирлын тушаалаар баталсан “Ур чадварын нэмэгдэл олгох журам”-ын дагуу улирлаар тогтоож, сар бүр 10-25 хувиар тооцож олгоно.

10.9.Үр дүнгийн мөнгөн урамшууллыг захирлын тушаалаар баталсан “Үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу улирал бүр 15-50 хүртэл хувиар тооцож олгож болно.

10.10.Ажлын зайлшгүй шаардлагаар ажилтныг илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажиллуулсан бол нөхөн амрах, нөхөн амруулаагүй бол дундаж цалин хөлсийг 1,5 дахин, нийтээр амрах баярын өдөр ажиллуулсан бол нөхөн амрах, нөхөн амруулаагүй бол дундаж цалин хөлсийг 2 дахин нэмэгдүүлж олгоно.

10.11.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил үүргийн дагуу гадаад, дотоодод сургалт, сэргээн засварлах, судалгаа шинжилгээний ажлаар ажиллахад:

10.11.1.Томилолтын зардлыг олгосон бол унаа, хоолны нөхөх төлбөрийг давхардуулан олгохгүй.

10.11.2.Томилолтын зардлыг олгоогүй бол унаа, хоолны нөхөх төлбөрийг олгоно.

10.12.Нэмэлт төсөл, хөтөлбөрийн хүрээнд ажиллаж цалин хөлс олгогдсон тохиолдолд унаа, хоолны нөхөх төлбөрийг олгохгүй, бямба, ням гарагт ажилласан бол нөхөн амрахгүй.

10.13.Ажилтны ажлын цагаас хоцорсон, эрт явсан цагийг ажил тасалснаар тооцох бөгөөд тухайн сард ажил тасалсан цагийн нийлбэр нь 4 цагаас дээш бол нийт ажилласан цагаас хасаж тооцно.

10.14.Ажлын цагийн ирц бүртгэлийг сар бүрийн 22-ны дотор гарган Захиргаа, удирдлагын газрын даргаар хянуулж, Санхүү, аж ахуйн албанд өгнө. Ажлын цагийн тооцоо нь тухайн ажилтанд цалин хөлс олгох үндэслэл болно.

Арван нэг. Шагнал, урамшуулал

11.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон бусад байгууллагын шагнал, “Жуух бичиг”, салбарын Тэргүүний ажилтан, Төрийн дээд шагналаар шагнуулах болзол хангасан ажилтныг харьяалах газар, нэгжийн хамт олны хурал, Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн шагналд тодорхойлно.

11.2.Ажилтны жилийн ажлын үр дүн, бүтээлч байдал, ажил үүргээ тогтмол гүйцэтгэлийн өндөр түвшинд биелүүлж, идэвх санаачилгатай ажилласан, онцгой амжилт, гавьяаг үнэлэн байгууллагын шилдэг ажилтанд тодорхойлно.

11.3.Шилдэг ажилтанд нэр дэвшүүлэх, олгох мөнгөн шагналын хэмжээг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, захирлын тушаалаар олгоно.

Арван хоёр. Тэтгэмж, тусламж олгох

12.1.Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд ажилтанд дараах тэтгэмж, тусламжийг “Ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн дагуу олгож болно. Үүнд:

12.1.1.Ажилтан өндөр насны тэтгэвэрт гарах тохиолдолд холбогдох хууль, журмын дагуу тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно.

12.1.2.Хөдөлмөрийн тухай хуулийн 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжийг Хөдөлмөрийн тухай хуулийн 82.1-д зааснаар олгоно.

12.1.3.Эх үрсийн баяр, шинэ жилийн баярын өдрийг тохиолдуулан ажилтны 0-16 насны хүүхдэд бэлэг өгч болно.

12.1.4.Ажилтан шинээр гэр бүл болоход 500,000 (таван зуун мянга) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгож болно.

12.1.5.Гэр бүлд шинээр хүүхэд мэндлэхэд 500,000 (таван зуун мянга) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгож болно.

12.1.6.Ажилтны гэр бүлийн гишүүн нас барсан тохиолдолд дараах байдлаар нэг удаагийн буцалтгүй тусламж олгож болно. Үүнд:

12.1.6.1.эхнэр, нөхөр, хүүхэд бол 1,000,000 (нэг сая) төгрөгийн,

12.1.6.2.төрсөн эцэг, эх бол 500,000 (таван зуун мянга) төгрөгийн,

12.1.6.3.төрсөн ах, эгч, дүү, хадам эцэг, эх бол 300,000 (гурван зуун мянга) төгрөгийн,

12.1.7.Ажилтны эхнэр, нөхөр, үр хүүхэд хүнд өвчнөөр өвдсөн бол гэр бүлд нь дэмжлэг үзүүлж нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлж болно.

12.1.8.Ажилтан хүндээр өвдсөн, хагалгаа хийлгэсэн бол түүнд нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлж болно.

12.1.9.Ажил үүргээ гүйцэтгэх явцад бие махбодод нь гэмтэл учирсан, нас барсан тохиолдолд Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиар зохицуулна.

12.1.10. Ажилтны ар гэрт гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас эд материалын хохирол учирсан нь тогтоогдсон бол Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн тусламж олгож болно.

12.1.11. Шахмал түлш болон гэр хорооллын утааг бууруулах ажлын хүрээнд цахилгаан халаагуур хэрэглэдэг, түрээсийн байранд амьдардаг (өөрийн эзэмшлийн орон сууц, хашаа байшингүй) ажилтанд жилд нэг удаа түлш, цахилгааны төлбөр, байрны төлбөрт дэмжлэг болгон нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлж болно.

Арван гурав.Ажил, амралтын цаг, ээлжийн амралт, ажилтныг ажиллуулахыг хориглох, хязгаарлалт

13.1.Ажлын цаг:

13.1.1.Ажлын цаг Даваа-Баасан гараг хүртэл 40 цаг байх бөгөөд ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 цаг байна. Ажил өглөө 08.30 цагт эхэлж, өдөр 12.30 цагаас 13.30 цагийн хооронд өдрийн хоолны цагаар завсарлаж, орой 17.30 цагт ажил дуусна.

13.1.2.Ажилтан ажилдаа ирсэн, ажил дууссан цагаа цаг бүртгэлийн төхөөрөмжид заавал бүртгүүлнэ. “Бүртгэл дутуу” (уншуулаагүй) бол энэ тухай Гадуур ажлын бүртгэлд тэмдэглэнэ. Гадуур (бусад байгууллагад) ажиллах үед газар, нэгжийн даргад мэдэгдэж, гадуур ажлын бүртгэлд тэмдэглэнэ (журмын 3 дугаар хавсралт).

13.1.3.Ажлын цагийн тооцоог ээлжийн амралтын мэдэгдэл, гадуур ажлын бүртгэл, эмнэлгийн болон чөлөөний хуудас, өргөдөл, холбогдох тушаал зэргийг үндэслэнэ.

13.1.4.Сар бүрийн цаг бүртгэлийн программын бүртгэлийг газрын дарга нарт цахимаар хүргүүлж, танилцуулна.

13.2.Жирэмсэн, гурав хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэй ажилтны ажлын цагийг уян хатан нөхцөлөөр ажиллуулахаар харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээсээ эсхүл зайнаас ажиллуулж болно.

13.3.Ажилтан өөр ажил олгогчтой зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллах тохиолдолд захиралд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд Үндэсний төвд ажиллах ажлын цагийг харилцан тохиролцож хөдөлмөрийн гэрээнд тусгасны дагуу ажлын 5 өдрийн 40 цагаас хасаж тооцно.

13.4.Хүүхэд хамгааллын зорилгоор эцэг, эхийн зөвлөл, Үйлдвэрчний эвлэлийн хорооноос ажилтны ажил амьдралын тэнцвэрийг хадгалахад дэмжлэг үзүүлэх санал гаргасан тохиолдолд Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

13.5.Амралтын цаг:

13.5.1.Ажлын зайлшгүй шаардлагаар илүү цаг, орон нутагт томилолтоор бямба, ням гарагт ажилласан, нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл хөлсийг олгоогүй бол ажилтныг ажлын 22 өдрийн дотор нөхөн амраана.

13.5.2.Долоо хоногийн амралтын өдөр байгууллагын нэрийн өмнөөс спортын уралдаан, тэмцээн, олон нийтийн арга хэмжээнд оролцсон бол нөхөн амраана.

13.6.Ээлжийн амралт:

13.6.1.Нийт ажилтны ээлжийн амралтын хуваарийг оны эхэнд газар, нэгжээс ирүүлсэн саналыг үндэслэн боловсруулж, захирлын тушаалаар батална.

13.6.2.Ажилтны хувийн болон ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтын хуваарьт өөрчлөлт орж болох бөгөөд энэ тохиолдолд захирал, газар, нэгжийн дарга холбогдох зохицуулалтыг хийнэ.

13.7.Ажилтныг ажиллуулахыг хориглох, хязгаарлалт:

13.7.1.Ажлын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд илүү цагаар, нийтээр амрах баярын өдөр, долоо хоногийн амралтын өдөр ажилтан өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд захиргааны санаачилгаар ажиллуулахыг хориглоно.

13.7.2.Жирэмсэн, гурав хүртэлх насны хүүхэдтэй, эсхүл 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдөр ажиллуулахыг хориглоно.

Арван дөрөв. Чөлөө олгох

14.1.Ажилтны хүсэлтээр дараах хүндэтгэн үзэх тохиолдолд олговортой чөлөөг захирлын тушаал, зөвшөөрлөөр олгож болно. Үүнд:

14.1.1.Засгийн газар хоорондын болон Үндэсний төвийн гадаадын мэргэжлийн байгууллагатай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээгээр тухайн улс орны байгууллагын урилга, шийдвэрээр 6 сар хүртэлх хугацаагаар мэргэжлийн дагуу сургалтад хамрагдах,

14.1.2.Ажилтны докторын диссертаци урьдчилсан хамгаалалтын шаардлагыг хангасан бол түүнд докторант хамгаалалтад нь дэмжлэг үзүүлж хуанлийн 15 хоногийн,

14.1.3.Ажилтны гэр бүлийн гишүүн нас барсан тохиолдолд дараах байдлаар чөлөө олгоно. Үүнд:

14.1.3.1.эхнэр, нөхөр, хүүхэд бол хуанлийн 10 өдөр,

14.1.3.2.төрсөн эцэг, эх бол ажлын 5 өдөр,

14.1.3.3.төрсөн ах, эгч, дүү, хадам эцэг, эх бол ажлын 3 өдөр.

14.1.4.Ажилтан гэрлэх, хүүхэд үрчлэх, үр хүүхэд нь хуримаа хийхэд ажлын 3 өдөр,

14.1.5.Ажилтанд хүнд, хэвтрийн өвчтэй төрсөн эцэг, эх, эхнэр нөхөр, үр хүүхдээ асарч сувилахад ажлын 5 өдөр,

14.1.6.Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон гэнэтийн аюул, ослын улмаас ажилтан ажилдаа ирээгүй бол (нотлох баримтаар нотлогдсон байх) түүнд ажлын 5 хүртэлх өдөр,

14.2. 14.1-д зааснаас бусад тохиолдолд ажилтны хүсэлтээр захирлын зөвшөөрлөөр цалингүй чөлөөг олгож болно.

14.3.Ажилтанд (ар гэрийн болон хувийн асуудлаар) ажлын 1 өдрийн цалинтай чөлөөг сард 1 удаа харьяалах газар, нэгжийн дарга, газрын даргад Захиргаа, удирдлагын газрын дарга олгож болно.

14.4.Ажилтан чөлөө авахдаа харьяалах газар, нэгжийн даргад, газрын дарга Захиргаа, удирдлагын газрын даргад заавал мэдэгдэнэ.

14.5.Ажилтны хүсэлтээр ажлын 10 хүртэлх өдрийн чөлөөг чөлөөний хуудсаар, 10 өдрөөс 1 сар хүртэлх чөлөөг захирлын тушаалаар олгоно. Чөлөөний хуудсыг Хүний нөөцийн ажилтнаас авна (журмын 4 дүгээр хавсралт).

14.6.Ажилтны өргөдөл хүсэлт, холбогдох нотлох баримтыг үндэслэн 3 сар хүртэлх хугацааны чөлөөг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж захирлын тушаалаар олгож болно.

14.7.Хуанлийн 1 сар ба түүнээс дээш хугацааны цалингүй чөлөө авсан ажилтан нийгмийн даатгалын шимтгэлийг өөрөө хариуцна.

14.8.Албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжлийн дагуу магистрантур, докторантурт суралцаж буй ажилтны сургуулийн албан ёсны хичээлийн хуваарийг үндэслэн суралцах хугацаанд дараах байдлаар цалинтай чөлөө олгоно. Үүнд:

14.8.1.хичээлийн хуваарьт өдрөө 4 цагаас дээш (цаг бүртгэлийн системд бүртгүүлсэн байх) ажилласан бол унаа хоолны нөхөх төлбөрийг олгоно.

14.8.2.хичээлийн хуваарьт өдрөө ажиллаагүй бол унаа хоолны нөхөх төлбөрийг олгохгүй.

14.9.Гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан (эцэг, эх) хүүхэд асрах хүсэлтээ бичгээр гаргах бөгөөд түүнд хүүхэд асрах чөлөөг олгоно. Ажилтан ажилдаа эргэн орох хугацааг хүсэлтэд дурдсан байна.

14.10.Засгийн газар, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гадаад улстай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, Үндэсний төвийн гадаадын мэргэжлийн байгууллагатай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээгээр тухайн улс орон, байгууллагын урилга, шийдвэрээр 3 сараас дээш хугацаагаар мэргэжлийн дагуу сургалтад хамрагдах ажилтны ажлын байрыг хадгалж, албан хаагчтай сургалтын гэрээ байгуулна.

14.11.Эрүүл мэндийн шалтгааны улмаас ажилдаа ирэх боломжгүй тохиолдолд харьяалах газрын даргад тухайн өдрөө эмнэлэгт үзүүлсэн эмнэлгийн хуудас, магадалгааг цахимаар мэдэгдэж, магадалгааг ажилдаа ирсэн өдрөө Хүний нөөцийн ажилтанд өгнө. Эмнэлгийн магадалгааг ирүүлээгүй тохиолдолд ажил тасалсанд тооцно.

Арван тав. Захиргааны эрх, үүрэг

15.1.Захиргаа нь дараах эрхтэй байна.

15.1.1.Үндэсний төвийн эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилтыг үндэслэн ажилтны албан тушаалын тодорхойлолтыг оновчтой тогтоож, баталж мөрдүүлэх,

15.1.2.Хуулийн хүрээнд хөдөлмөрийн харилцааг өөрчлөх, дуусгавар болгох,

15.1.3.Ажилтнаас хөдөлмөрийн гэрээ, дотоод журмын дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх,

15.1.4.Ажилтны буруутай үйл ажиллагааны улмаас техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, компьютер зэрэг эд зүйлийг эвдэж гэмтээвэл гэмтлийг засуулах, эсхүл төлүүлэх арга хэмжээ авах,

15.1.5.Хууль, тогтоомжид заасан бусад эрх.

15.2.Захиргаа нь дараах үүргийг хүлээнэ.

15.2.1.Ажилтанд хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс, урамшуулал олгох, ээлжийн амралтыг эдлүүлэх,

15.2.2.Байгууллагаас баталсан дүрэм, журмыг танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах,

15.2.3.Ажилтныг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бичиг хэргийн материалаар хангах, хөдөлмөр хамгааллын зааварчилгаа өгөх, сургалт явуулах, ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх,

